

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 26 оны 08. сарын 20. өдөр

№ R-2026-37

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай


Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8.6 (ii) дахь заалтыг тус тус үндэслэн, Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2026 оны 08 дугаар сарын 19-20-ны өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банк нь 2026 оны эхний хагас жилийн байдлаар 88.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 18.4%-д хүргэж ажилласан болохыг;
2. Банкны Дүрэмд зааснаар ногдол ашиг хуваарилах асуудал нь стратегийн асуудал болохыг;
3. Банкны гүйцэтгэх удирдлага нь Банкны 2026 оны эхний хагас жилийн ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг мөнгөн хэлбэрээр хуваарилах ("Хагас жилийн ногдол ашиг")-ыг ТУЗ-д санал болгосныг; мөн
4. ТУЗ нь Банкны Дүрмийн 8.6 (ii) дахь заалтын дагуу дор дурдсан дүнгээр Хагас жилийн ногдол ашгийг зарлан хуваарилах шийдвэр гаргуулахаар хувьцаа эзэмшигчдэд санал болгож буйг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Монголбанкнаас зөвшөөрч, хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн баталсан тохиолдолд, Хагас жилийн ногдол ашигт нэгж хувьцаанд 18.0 (арван найм) төгрөг зарлан хуваарилахыг дэмжсүгэй.
2. Монголбанкнаас зөвшөөрч, хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("ХЭЭБХ")-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг тухайн хурал зохион байгуулагдах хэлбэрээс үл хамааран Хагас жилийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Монголбанкнаас зөвшөөрч, хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойш 7 хоногийн дотор Хагас жилийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлсүгэй. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 дугаар "Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай" тогтоолд заасны дагуу, Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь бичгээр



урьдчилан хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ХУУЛЬ, ХЯНАН НИЙЦҮҮЛЭЛТ
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БОГООД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА



Н.МӨНХЦЭЛМЭГ

ХАСБАНК ХК

Үнэт цаасны үнэ, ханшид нөлөөлж болох мэдээлэл

Тухай бүр мэдээлэх мэдээлэл /маягт 3/	
Тайлагнах хугацаа	2026 оны 08 дугаар сарын 21-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	Нэр: ХасБанк ХК УБГД: 000239852 РД: 2578697 Үнэт цаасны код: MN00XAC05687 Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, СБД, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр, ШХ 20А, 72 Утас: 75771888 И-майл: info@xacbank.mn Вэбсайт: www.xacbank.mn
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүүгийн салбар
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,052,700,000 ширхэг энгийн хувьцаа
Тухай бүр мэдээлэх мэдээллийг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Н.Цэлмэгхишиг, ТУЗ-ийн ажлын албаны хуульч Хянасан: Н.Мөнхцэлмэг, Хууль, хянан нийцүүлэлт хариуцсан захирал бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга
1. Ногдол ашиг хуваарилах тухай	
ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2026 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн R-2026-37 дугаар тогтоолоор Банкны 2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг зарлан хуваарилахыг дэмжиж Хувьцаа эзэмшигчдэд санал болгохоор шийдвэрлэсэн болно.	
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	

Овог, нэр: Н.Цэлмэгхишиг

Албан тушаал: ТУЗ-ийн ажлын албаны хуульч

Гарын үсэг:



Хянасан: Н.Мөнхцэлмэг

Албан тушаал: Хууль, хянан нийцүүлэлт хариуцсан захирал бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:



Огноо: 2026 он 08 сар 21 өдөр